



Sapper Platoon for Demolition and Restoration

Banzragch Munkhsaikhan

Ph.D, Professor, Researcher, Innovation and technology transfer center,
Defense Research Institute of Mongolia

E-mail address: munkh.ing1964@gmail.com, ORCID: 0009-0001-8713-1286

Received: 06 February 2026
Accepted: 25 March 2026

Revised: 15 March 2026
Published online: 30 March 2026



ABSTRACT

The Engineer Corps is one of the most remarkable branches of the military, distinguished by its specialized professional role and rich historical legacy. Engineer troops are uniquely characterized by their participation at the forefront of virtually all types of combat operations. Unlike other military branches, their mission does not end with the conclusion of warfare or combat actions; instead, their responsibilities continue during the post-conflict period through recovery, reconstruction, and technical support activities.

In the present context, it is necessary to reexamine and highlight certain significant events in the history of the national armed forces. In particular, this article focuses on the first engineer unit, known as the “Demolition and Repair Sapper Platoon,” examining its formation, role, and historical significance.

Keywords: Sapper, military engineer, engineer corps, sapper platoon, military branch history.

“Эвдэх ба сэлбэн засах сапёр” хэмээх салааны тухай

Банзрагч Мөнхсайхан

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Инновац, технологи дамжуулалтын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), профессор
munkh.ing1964@gmail.com, ORCID: 0009-0001-8713-1286

ХУРААНГУЙ:

Инженерийн цэрэг нь тун ч гайхамшигт түүхтэй, тусгай мэргэжлийн төрлийн цэргийн нэг юм. Инженерийн цэрэг нь аль ч төрлийн байлдаанд үүрэг гүйцэтгэхэд хамгийн тэргүүн эгнээнд оролцдог онцлогтой ба дайн, байлдааны ажиллагаа дууссан ч тэдний хувьд энэ ажиллагаа дуусдаггүй үргэлжилдэг ганцхан төрөл мэргэжлийн цэрэг юм.

Энэ цаг үед үндэсний цэргийн түүхийн зарим үйл явдлыг, тодотгох шаардлагатай бөгөөд тухайлбал инженерийн цэргийн анхны салаа болох “Эвдэх ба сэлбэн засах сапёр” хэмээх салааны тухай энэхүү өгүүлэлд өгүүлэх болно.

Түлхүүр үг: Сапёр, инженер, инженерийн цэрэг, салаа, салбарын түүх

ОРШИЛ

Цэргийн түүх судлаачид инженерийн цэрэгт хандуулсан төдий л их биш

байдаг. Учир нь цэрэг, дайны түүхийн судалгаанд инженерийн цэргийн талаар тусгайлан авч үзсэн нь ховор хэдий ч, магадгүй тэд ялалт байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн байхыг үгүйсгэхгүй юм.

Инженерийн цэргийн үүсэл, хөгжил нь нэн эртний түүхтэй бөгөөд Монгол нутагт анхны төр үүссэн тэр л цагаас монголчуудын цэргийн инженерийн ухаан, урлаг үүссэн болохыг манай эрдэмтэд тогтоогоод байна. Дайн, мөргөлдөөн, гарах бүр өөрийн цэргийн амьд хүчийг хамгаалах, эсрэг талын үйл ажиллагааг саатуулах, тэдэнд хохирол учруулахын тулд олон төрлийн арга ажиллагааг хэрэглэн, улам боловсронгуй болгон хөгжүүлж ирсэн нь цэргийн инженерийн хэргийн суурь, эхлэл болсон юм.

XIII зууны монголчуудын их аян дайныг Чингис хаан эхлүүлсэн цагаас монголчуудын инженерийн цэргийн хөгжил, арга ухаан шинэ шатанд гарсан гэж үздэг бөгөөд энэхүү хөгжил нь цагийн эргэлтэд хөгжин баяжсаар орчин үеийн байлдааны инженерийн хангалтын үүрэг болж, байлдааны хангалтын бие даасан нэгэн төрөл болтлоо хөгжиж иржээ.

Энэ мэт түүхэн баримтууд нь Америкийн эрдэмтэн Ж.Д.Вернадскийн ”XIII зууны монголын арми бол тэр үеийн дэлхий дахины хамгийн шилдэг арми байсан нь ямар ч эргэлзээгүй. Энэ морьт арми нь хэрэм, боомт эвдэх инженерийн ангитай байжээ” хэмээн хэлснийг нотлох бөгөөд инженерийн цэргийн түүх, дайчин замнал нь өнө эртний улбаатай, ирээдүй хойчийн залгамж, холбоотой болохыг харуулдаг.

Орчин үеийн Зэвсэгт хүчний хөгжлийн түүхэнд инженерийн цэргийн гүйцэтгэж ирсэн түүхэн үүрэг, ач холбогдол үнэлж баршгүй их юм. Аливаа шинэ зэвсэг буй болохын хамт тэдгээртэй тэмцэх шинэ арга хэрэгсэл, шинэ техник, технологийг нэхдэг ба өнөөгийн дэлхийн инженерийн цэргийн хөгжил ч энэхүү жамыг тойрч гараагүй юм. Ялангуяа дэлхийн I, II дайны жилүүдэд Европын орнууд, тэдгээрийн дотор Зөвлөлт Холбоот Улсын инженерийн цэргийн урлаг, хөгжил дэвшилд оруулсан хувь нэмэр, олсон өндөр амжилт нь манай улсын хувьд тусгалаа олж, түүний тусламжтайгаар Монголын Ардын журамт цэрэг (МАЗЦ)-т цоо шинэ маягийн байнгын цэрэг, армийн бааз суурь бий болсон төдийгүй инженерийн цэрэг үүсэн хөгжиж ирсэн хэмээн түүхэнд тэмдэглэсэн байдаг.

Цэргийн түүхийн хуудаснаа орчин цагийн Зэвсэгт хүчний инженерийн цэргийн үүссэн цаг хугацааг яг тодорхойлсон баримт бичиг ховорхон байдаг тул энэ төрөл мэргэжлийн цэргийн үүссэн өдрийг тодруулах зорилгоор тус судалгааг явууллаа. Батлан хамгаалахын төв архивд байгаа зарим эх сурвалжийг ашиглан, түүхэн он цаг хугацааг урагшлуулж Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний тэмдэглэлт өдрийг нэгээр нэмэгдүүлэхийн чацуу энэхүү гайхамшигт цэргийн анхдагч нарын байгуулсан гавьяа зүтгэлийг хойч үедээ мөнхлөн алдаршуулах, түүхийн цагаан толбыг арилган, тодруулах зорилт тавьж ажиллалаа.

Ингэснээр хэдийгээр уламжлал болон тэмдэглэдэг инженерийн цэргийн ууган салбар 1944 онд үүсэн байгуулагдсан ойг цааш урагшлуулж, тодотгох нь энэхүү өгүүллийн дэвшүүлж байгаа асуудлын мөн чанар орших бөгөөд орчин цагийн Зэвсэгт хүчинд Инженерийн цэргийн эзлэх байр суурийг улам батжуулж, өгөх болно.

Үүсэн бий болох түүхэн нөхцөл

МАЖЦ 1921-1922 онд манай орны баруун ба төв, зүүн хэсгийг цагаантнаас чөлөөлөх байлдааны үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж явуулсан бөгөөд нийтдээ 200 орчим их, бага байлдаан тулалдаан явуулсан гэж түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Энэ үед инженерийн цэрэг үүсэж буй болоогүй ч инженерийн хангалтын үүргийг хэрэгжүүлж, эртний монгол цэргийн уламжлал, Зөвлөлт Орос Улсын Ажилтан тариачны улаан армийн ангиудын байлдааны ажиллагааны түүхэн баримтад сургагч нарын зааж зөвлөснөөр гүйцэтгэж, шинэ төрөл мэргэжлийн цэргийн нэг болох инженерийн цэргийн үр хөврөлийг буй болгосноор цаашид хөгжих үндэс нь болсон байдаг.

Шинээр бүрэлдсэн ардын засгийн газар эх нутгаа харийн түрэмгийлэгчдээс чөлөөлж, улс орноо төвшитгөн МАЖЦ-г бэхжүүлэх зорилтоо тухайн цаг үед амжилттай шийдвэрлэсэн билээ. Монгол Улсын засгийн газар 1921 оны есдүгээр сарын 25-нд Цэргийн яамны орон тоог шинэчлэн баталснаар, дараагийн жилүүдэд цэргийн удирдлага, зохион байгуулалт улам боловсронгуй болж, хүн хүч бүрэлдэхүүнээр нөхөн хангагдаж, орон тоо нь өсөв.

1924 оны байдлаар гэхэд:

- Бүх цэргийн зөвлөл, Цэргийн яам 42,
- Сурган боловсруулах хэлтэс 56*,
- Бүх цэргийн бэлтгэл 52,
- Харилцан нэвтрэлцэх хэлтэс 187**,
- Гадаад тагнуулын хэлтэс 11,
- Эмчийн хэлтэс, амбулатори, аптека,
- Орос лазерт 62,
- Зэвсгийн хэлтэс, засвар 30,
- *Инженерийн хэрэг эрхлэх ба барилгын хэлтэс 5*, нийт 445 хүн цэргийн удирдах байгууллагад ажиллаж байв. гэж баримтад (*Гомбосүрэн Д. 2012*) үлджээ.

Харин 1927 оны үед “Инженерийн хэрэг эрхлэх ба барилгын хэлтэс” Бүх цэргийн бэлтгэлийн Инженерийн тасаг нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж тасгийн даргаар нэрт хувьсгалч, ард түмэндээ “Нанзад баатар” хэмээн алдаршсан Дамирангийн Нанзад ажиллаж (*“Батлан Хамгаалахын Төв Архив”*, х.н) байжээ.


Инженерийн цэрэг нь МАЖЦ-ийн үүсэн тогтносон хөгжилтэй салшгүй холбоотой бөгөөд анх манай цэргийн бүрэлдэхүүнд 1927 оны эцсээр туршилтын журмаар Инженер-сапёрын салааг 1 дүгээр Морьт хорооны орон тоонд оруулж байжээ.

Бүх цэргийн зөвлөлийн 1929 оны 9-р сарын 20-ны өдрийн 45 тоот тогтоолоор 1 дүгээр морьт хорооны суурин дээр байгуулсан 1 дүгээр морьт дивизийн бүрэлдэхүүнд инженерийн цэргийн анхны салааг оруулсан байдаг. Тэр салаа нь 1928-1929 оны үед буй болсон нь архивын зарим материалд, орон тоо, цалингийн бүртгэл хэлбэрээр үлджээ.

Тухайлбал: Батлан хамгаалахын төв архивын хадгаламжийн нэгжийн 1-ийн 1-гийн 1вв-д байгаагаар 1928 оны эцэст 1мбр-ийн орон тоонд тэмдэглэхдээ: тайлбарлах нь гээд энэ бол 1928 оны (олноо өргөтгөсөн 18 оны) цэргийн харьяат олон газрын орон тоо (*“Батлан Хамгаалахын Төв Архив”*, х.н 1.1.1вв) гэжээ. Энэ

Бидэнд олдсон баримтаас харахад, салааны дарга-19 төгрөг, сургагч-165 төгрөг, туслах дарга орчуулагч-12 төгрөг, эвдэх ангийн аравны дарга-9 төгрөг, зам ба гүүр ангийн аравны дарга-9 төгрөг, хэсгийн дарга-5 төгрөг 61 мөнгө, цэрэг- 2 төгрөг 85 мөнгө, ачаатай морь хөтлөгч- мөн хөсөгч 2 төгрөг 85 мөнгөний цалинтай, бүгд 34 хүн 4862 төгрөг 88 мөнгөний цалинтай (*“Батлан Хамгаалахын Төв Архив”, х.н 166*) байв.

Энэхүү салааны зэвсэг хэрэгсэл нь жижиг хүрз, сапёрын хэмээх том хүрз, жоотуу, сүх, лоом, хөрөө гэх мэт ажлын багаж хэрэгсэл нь ердийн боловч тухайн үед инженерийн ажлыг гүйцэтгэж байсан ба одоо ч үнэ цэнээ алдаагүй байна.



Зураг 1. Ажлын багаж хэрэгсэл: а – сапёрын том хүрз; б – мужааны сүх; в – явган цэргийн жижиг хүрз; г-жоотуу; д – лом царил; е – гар хөрөө; ж – хэмжүүрийн татлага олс.

“Эвдэх ба сэлбэн засах сапер”-д томилогдсон анхны салааны удирдлага, бүрэлдэхүүний тухай мэдээлэл Батлан хамгаалахын төв архивд одоогоор олдоогүй бөгөөд Бүх цэргийн зөвлөлийн архивын материал хожим ямар нэгэн байдлаар илрэх үед тодотгож болно гэж үзэж байна.

Хэлэлцүүлэг

МАЖЦ 1930-аад оноос шинэ бүтэц зохион байгуулалтад шилжиж эхэлсэнтэй холбогдуулан Цэргийн явдлын яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 1932 оны 3 дугаар сарын 12-ны 41 тоот тушаалаар тус бүр 2 морьт дивиз бүхий морьт корпусыг байгуулсан юм. 1935 оны эхнээс БНМАУ-ын дорнод хил дээр зэвсэгт

өдөөн хатгалгааг удаа дараа явуулж эхэлсэн эгзэгтэй үед цэргийн анги салбарыг яаралтай өргөтгөснөөр бүрэлдэхүүн, тооны хувьд ч анх өсжээ. Ардын Сайд нарын зөвлөлийн 1937 оны 9 дүгээр сарын 13-ны 25 тоот тогтоолоор 2 морьт корпусыг өөрчлөн 5,6,7,8, 10 дугаар Морьт дивиз болгон Халхын гол, Тамсагбулаг, Хэрлэн, / ӨндөрХаан/ -д байрлуулж бүрэн дуусгаагүй үе байв.

“Монгол цэргийн түүхийн товчоо” II –ботид хуудас/184/ 1941-1942 онд төрөл мэргэжлийн цэргийн ангиудыг шинээр зохион байгуулсан гэж дурдсаныг анхаарч үзэхгүй байж боломгүй байна. Энэ нь Морьт дивизэд шинэ анги салбар хэмээгдсэн түүний дотор 1941-1942 онд төрөл мэргэжлийн цэргийн ангиудыг шинээр байгуулсан тухай тэмдэглэснээр Морьт дивизийн инженерийн хагас суманг 1941-1942 онд байгуулсан байна гэж ойлгож болох байна.

Үүнээс гадна 1942 оноос ихэнх офицерууд инженерийн салаа, салбарын даргаар томилогдсон нь бүр ч 1942 онд инженерийн хагас сумангийн орон тоо Морьт дивизийн орон тоонд гэх бүрэн үндэслэл болж байна. Ийнхүү инженерийн хагас суман МБр-д инженер саперын салаа буй болж үүрэг гүйцэтгэж иржээ.

Үүгээр ямар нэгэн онцгой өөрчлөлт оруулалтгүй байгуулсан нь инженерийн зарим офицерын хувийн хэргийг үзэхэд сүүлд 1934, 1936 оны үед Б. Нанзад, Б. Лувсандорж, Н.Бадлай нарын офицерууд ээлжлэн инженерийн салааны захирагчаар 1 болон 5 дугаар морьт дивизэд ажиллаж байсан бөгөөд өөр инженерийн гэхээр офицерууд харагдахгүй байна.

Энэ нь 1929 оноос 1941, 1942 оныг хүртэлх хугацаанд 1 болон 5 дугаар морьт дивизийн инженерийн салаанаас өөр инженерийн гэх салбар, салбар байгаагүй юм байна гэсэн товч дүгнэлтэд хүрч байна. Дээрх хугацаанд өөр инженерийн салбар, байгаагүй нь дараах архивын материалаар нотлогдоно. Ардын хувьсгалт цэргийн байлдааны хүчийг батжуулах ба улс орныг батлан хамгаалах талаар 1941-1945 онд авсан үндсэн арга хэмжээтэй тухай БХЯ-наас бэлтгэж Намын Төв Хороонд оруулсан тайлан илтгэлд дурдсанаар: “1939 оны МАХЦ-ийн морьт дивизийн байлдааны орон тоонд инженерийн хагас суман байхгүй (*“Батлан Хамгаалахын Төв Архив”, х.н 4в*) байсан бол 1945 оны байдлаар орон тоонд саперын хагас суман 82 хүнтэйгээр орсон (*“Батлан Хамгаалахын Төв Архив”, х.н 15*) байна.” гэжээ.

6 сарын хугацааны офицеруудын цугларалт явуулсан ба инженерийн ротуудад 55 тооны бага дарга нарыг бэлтгэж гаргасан гэжээ. Үүнээс үзэхэд анги, нэгтгэлийн саперын салбар нь инженерийн хагас суман болж таарч байна. Дэлбэлэх тэслэх зүйлд суралцах, ашиглах ажиллагаанд сургалтын хугацаа шаардагдах учир урьдах салааны сургалт дадлагын тооцоог илтгэсэн бололтой. 6 сарын офицеруудын цугларалтыг офицер бэлтгэх түр курс гэж ойлгож болох талтай.

Эдгээр баримтаас гадна:

Үндэсний офицерын шинэ хүчнийг бэлтгэх талаар гэсэн 5-дахь хэсэгт Бүх төрөл мэргэжлийн офицеруудыг явуулах тухай 1943, 1944, 1945 оноор тус тусад нь тооцсон байна. Мөн үүнээс гадна цэргийн инженерийн академид 1 хүн явуулсан нь д/х Д. Гэсэржав бололтой. Харин цэргийн инженерийн дунд сургуульд 1942 онд 8 хүн явуулж, 1945 онд 7 хүн төгссөн. 1944 онд 9 хүн явуулж, 1947 онд 9 хүн төгссөнөөр тухайн үед офицер боловсон хүчнээр хангагдах нөхцөл бүрдсэн гэж үзэх үндэслэлтэй.

Тухайн үед 6 МД-ийн инженерийн албаны дарга бөгөөд инженерийн хагас сумангийн дарга байсан Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн хурандаа Баатарын Самбуу гуай өөрийн дурсамждаа: “Уг суман нь 2 салаатай, салаа бүр хоёр тасагтай, бараг л ердийн морин суман байсан бөгөөд ус нөөцлөх резинэн сав, ус өргөх хэрэгсэл, инженерийн нэг бүрийн багаж хэрэглэлээр илүүтэйн гадна сургалт нь инженерийн бэлтгэлийн хувьд арай өөр, анги салбарын дайчдад сургах зааварлах боломжтой. Ихэнхдээ зааж зааварладаг байв” гэж дурссан байна. Инженерийн албан хааж байсан офицеруудын хувийн хэргийг үзэхэд ихэнх нь 1942,1943,1944 оноос эхлэн инженерийн цэрэгт алба хаажээ.

МБр-ийн орон тоонд инженерийн хагас суман албаны орон тоо буй болмогц ЗХУ-д цэргийн инженерийн сургуульд 1942 оноос эхлэн олон тоогоор хүн сургах болсон гэж үзэж байна. 1942 оны 07-р сарын 07-ны өдөр орлогч жанжны 00115 тоот тушаал гарч Жанжин штабын орон тоонд цэргийн инженерийн хэлтсийг буй болгож орон тоог батлан мөрдүүлжээ. Үүний дараа асар удалгүй Цэргийн явдлын яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 1942 оны 9 дүгээр сарын 9-ны өдрийн 0144 тоот тушаалаар ЗХУ-д ерөнхий цэргийн академи төгсөж ирсэн Очиржав овогтой Чойжилжав гэдэг хүнийг даргаар нь томилсон (*“Батлан Хамгаалахын Төв Архив”, х.н 33*) байна. Ийнхүү инженерийн салбарууд нэмэгдэж мэргэжлийн удирдлагаар хангах шаардлага гарч энэ нь тодорхой болж байна. Энэ нь МД-д инженерийн хагас суман нэмэгдсэнтэй ч холбоотой байж болох юм.

Дүгнэлт

1944 оноос хойш инженерийн тусгай салбар буй болж өөрийнхөө түүхэн замналыг бүтээж ирсэн бөгөөд Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжны 1944 оны 8-р сарын 19-ны өдрийн 0112 тоот тушаалаар Армийн инженер саперын 1-р тусгай рот байгуулагдаж, улмаар 1964 онд Инженер саперын тусгай батальон, 1980 онд Инженер саперын тусгай хороо болон өнөөг хүртэл үүргээ нэр төртэй биелүүлж, алдар гавьяаны 2 одонтой, түүхт 80 жилийн ойгоо 2024 онд тэмдэглээд байна.

Батлан хамгаалахын сайдын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн а/368 тоот тушаалаар Зэвсэгт хүчний төрөл мэргэжлийн цэргийн өдрүүдийг баталсан бөгөөд тушаалын хавсралтын 9-т инженерийн цэргийн өдрийг тогтоохдоо “Армийн саперын тусгай рот” нэртэйгээр анхны инженерийн салбар байгуулагдсанаар Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн эх суурь тавигдсан гэж үзсэн байдаг.

Иймд энэхүү судалгааны үр дүнгээр Бүх цэргийн зөвлөлийн 1929 оны 9-р сарын 20-ны өдрийн 45 тоот тогтоолоор 1 дүгээр морьт дивизийг байгуулж, түүний бүрэлдэхүүний 1мбр –ын орон тоонд “Эвдэх ба сэлбэн засах сапёр” хэмээх инженерийн цэргийн анхны салааг оруулсан өдрөөр үндэслэн жил бүрийн 9-р сарын 20-ны өдрийг “Зэвсэгт хүчний инженерийн цэрэг” үүсэж бий болсон өдөр, түүнчлэн 8-р сарын 19-ны өдрийг “Зэвсэгт хүчний 014 дүгээр анги байгуулагдсан өдөр” гэж сайдын тушаалаар шинэчлэн тодотгох, нэмэлтээр оруулах саналтай байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. “Батлан Хамгаалахын Төв Архив.”. Улаанбаатар. Сан хөмрөг 1, Д1. Хадгаламжийн нэгж 166.

2. “Батлан Хамгаалахын Төв Архив.”. Улаанбаатар. Сан хөмрөг 1. Хадгаламжийн нэгж.
3. “Батлан Хамгаалахын Төв Архив.”. Улаанбаатар. Сан хөмрөг 1. Хадгаламжийн нэгж 1.1.1вв.
4. “Батлан Хамгаалахын Төв Архив.”. Сан хөмрөг 2, Товъёог 34,. Хадгаламжийн нэгж 33.
5. “Батлан Хамгаалахын Төв Архив.”. Улаанбаатар. Сан хөмрөг 12, тт-26. Хадгаламжийн нэгж 4в, хуудас 1-52.
6. “Батлан Хамгаалахын Төв Архив.”. Сан хөмрөг х12 т-26. Хадгаламжийн нэгж 15, Хуудас 30-78.
7. Гомбосүрэн Д. 2012. *Монгол Улсын Зэвсэгт Хүчний Байгуулалтын Түүх: ХХ Зуун*. Улаанбаатар.